

## Найрамдлын хороо

1951-7-23-нд Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1241-р тотоолын 2 дугаар хавсралтаар Улаанбаатар хотын хороодын орон тоог хорооны дарга, нарийн бичгийн дарга, бичиг хэрэг бөгөөд бичээч, комендант, зарлага, галч, цэвэрлэгч хорьдын дарга бүгд 1 хороог 150 орон тоотой жилийн цалингийн фондыг 329200 төгрөгөөр тогтоожээ.

Улаанбаатар хотын засаг захиргааны зохион байгуулалтанд өөрчлөлт оруулсан 1956-8-11-ний зарлигийг хүчингүй болгожээ.

1959-8-14-нд УИХ-ын Тэргүүлэгчдийн 133 дугаар зарлигаар Найрамдлын хорооноос 10-11,12,13,14,15,16 дугаар хорин

Чингэлтэйн хорооноос 9,10-р хорин

Сүхбаатарын хорооноос 5-р хорин

Чойбалсангийн хорооноос 9-р хорин

Эдгээр хорьдыг дээрхи хороодоос хасч бүгд 11 хориныг шилжүүлэн Зүүнсэлбийн хороог шинээр байгуулсан.

1965-4-14-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 79 дүгээр зарлигаар Нийслэл Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын харьяа Ажилчин, Найрамдал, Амгалан, Зүүнсэлбэ, Сүхбаатар, Хоршоолол, Чингэлтэй, Толгойт, Октябрь, Төмөр замын хороог татан буулгаж, Сүхбаатар, Октябрийн, Ажилчин, Найрамдлын районыг байгуулж Улаанбаатар хотын районы АДХ-ын сонгуулийг орон нутгийн хурлын 7дахь удаагийн ээлжит сонгуультай хамтатган явуулахаар тогтоожээ.